

## АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....	3
1.1. Төслийн нэр .....	3
1.2. Төсөл хэрэгжүүлэгч компани.....	3
1.3. Уурхайн хүчин чадал.....	3
1.4. Төслийн байршил.....	4
1-5. Уурхайн ашиглалтын систем.....	5
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ.....	7
2.1 Төсөл хэрэгжих орчны байршил, физик газарзүйн нөхцөл .....	7
2.2 Уулзүй .....	8
2.3 Ус зүй .....	8
2.4 Хөрс .....	9
2.5 Ургамал зүй .....	10
2.6 Амьтны аймаг .....	11
2.7 Нийгэм, эдийн засаг .....	12
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	13
3-1. Экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдал .....	13
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15
4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	16
4.1.1 Агаар орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	16
4.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	20
4.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	21
4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	21
4.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	22
4.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	23
4.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	24
4.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	25
4.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	27
4.10 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө .....	28
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал .....	29

## **ЗУРАГ**

Зураг 1-1. Төслийн талбайн байршлын зураг .....	4
Зураг 2-1. Байгалийн бүс бүслүүр .....	7
Зураг 2-2. Өндөржилтийн зураг .....	8
Зураг 2-3. Ус зүйн зураг .....	9
Зураг 2-4. Төслийн талбай орчмын хөрсний зураг .....	10
Зураг 2-5. Төслийн талбай орчмын ургамлан бүлгэмдлийн зураг .....	11

## **ХҮСНЭГТ**

Хүснэгт 1-1. Төслийн товч танилцуулга .....	3
Хүснэгт 1-2. Уурхайн ажиллах горим .....	4
Хүснэгт 1-3. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлын цэгүүд .....	5
Хүснэгт 1-4 Тэрбум мод төслийн хүрээнд таригдсан модны усалгаанд 6955м <sup>3</sup> ус ашиглана. .....	6
Хүснэгт 1-5 2026 оны усны хэрэглээ .....	6
Хүснэгт 1-6 Цахилгааны хэрэглээ .....	6
Хүснэгт 2-1. Болзошгүй тохиолдох ховор ургамлууд .....	11
Хүснэгт 2-2. Улаан номонд орсон боломжит зүйлс .....	12
Хүснэгт 3-1 Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа .....	13
Хүснэгт 4-1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	16
Хүснэгт 4-2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	20
Хүснэгт 4-3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	21
Хүснэгт 4-4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....	21
Хүснэгт 4-5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	22
Хүснэгт 4-6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	23
Хүснэгт 4-7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	24
Хүснэгт 4-8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	25
Хүснэгт 4-9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	27
Хүснэгт 4-10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө .....	28
Хүснэгт 5-11. 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардал .....	29

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн нэр

Галтын амны дээд хэсгийн алтны шороон ордыг ашиглах төсөл

#### **Төслийн зорилго, ач холбогдол:**

Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар төсөл хэрэгжүүлэх 5 жилийн хугацаанд 391,73 мян.м3 элс угаан баяжуулж, 425,51 кг алт борлуулах ба тодорхой тооны хүмүүсийг ажлын байраар ханган, өөрийн компанийн болон улс, орон нутгийн эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх, Ашигт малтмалын тухай хуулийн 35.5-д заасны дагуу ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглахад чиглэгдэнэ.

### 1.2. Төсөл хэрэгжүүлэгч компани

Төсөл хэрэгжүүлэгч “Ай Би Би Ай” ХХК нь уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдсан Монгол улсын 9011453143 тоот улсын бүртгэлийн дугаартай, аж ахуйн нэгж юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь MV-020602 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг эзэмшдэг ба өөр чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй, зөвхөн энэ төсөл дээр төвлөрөн ажиллаж байгаа юм.

**Хүснэгт 1-1. Төслийн товч танилцуулга**

Аж ахуйн нэгжийн нэр	“Ай Би Би Ай” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011453143
Регистрийн дугаар	5809797
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл	MV-020602
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон огноо	2016
Ашиглалтын талбай	3506,94 га
Төслийн байршил, хаяг	Төв аймгийн Заамар сумын нутагт орших. Улаанбаатар хотоос баруун хойш 195км, заамар сумаас баруун тийш 35км тус тус зайтай оршино.

### 1.3. Уурхайн хүчин чадал

2026 онд Галтын амны алтны шороон ордын хайгуулын 66-80 шугам хоорондын В-3 блокийн үлдэгдэл 60%, С-1, В-1, В-2 блокуудыг бүрэн, Туул голын баруун дэнж ХШ 0-14 хэсгийн бүх блокийг бүрэн ашиглахаар төлөвлөж байна. Төлөвлөгөөт онд 27,3 га талбай шинээр уулын ажилд, 3,2 га талбай шимт хөрсний овоолго үүсгэхэд, 5,1 га талбай гадаад овоолго үүсгэхэд, 1,0 га талбай зам хийхэд өртөнө.

Галтын ам хэсэгт уурхайн дундаж гүн 90,0м, Туул дэнжийн хэсэгт 32,0м байх юм.

Уурхайн олборлолтын талбайгаас 75,9 мян.м3 өнгөн хөрс, 7898,3 мян.м3 үндсэн хөрс хуулан дунджаар 1080мг/м3 агуулгатай 187,53 мян.м3 элс олборлон баяжуулж, химийн цэврээр 202,527 кг алт олборлохоор тусгаж байна.

Уулын ажил явуулж байсан өмнөх жилүүдийн туршлага дээр тулгуурлан уулын ажлыг тээвэрлэлтийн журмаар дараах дарааллаар гүйцэтгэнэ. Үүнд:

- Уулын ажил явуулах болон нөлөөлөлд өртөх талбайн 0,2-0,4м зузаантай шимт хөрсийг тусгай овоолго руу зөөвөрлөх
- Карьер руу орох замыг бэлтгэх
- Хөрс хуулалтын ажлыг доголоор явуулж гадаад болон дотоод хөрсний овоолгыг хийнэ.

- Элс олборлолтыг хэсэгчлэн овоолго руу зөөх

Элсийг угаах төхөөрөмж рүү хүргэх зэрэг болно.

Ил уурхайн уулын ажлыг тээвэрлэлтийн системээр экскаватор, автосамосвалын хослолын ашиглалтын системээр гүйцэтгэнэ.


Галтын амны дээд хэсгийн гүний алтны шороон ордын олборлолтын ажил 2026 оны 1-11 саруудад ажиллана. Уулын ажил хоногт 2 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байна.

**Хүснэгт 1-2. Уурхайн ажиллах горим**

Хийгдэх ажлууд		Уулын ажил явуулах сарууд												Нийт	
		Хэмжих нэгж	1	2	3	4	5	6	7	8	9	10	11		12
Хөрс хуулагт	Шимт хөрс	мян.м <sup>3</sup>		5	6.5	7	9	9	9	9	9.4	6	6		<b>75.9</b>
	Хучаас	мян.м <sup>3</sup>	182	125	790.74	848.6	800	949.89	953.64	982.88	842.86	710.99	711.84		<b>7898.4</b>
Элс олборлолт		мян.м <sup>3</sup>	4	3	14.48	15.83	10	22.18	24.36	22.88	18.41	23.86	22.72	5.79	<b>187.51</b>
Элс угаалт		мян.м <sup>3</sup>	3	3	10	15	15	20	25	23	20	20	20	13.51	<b>187.51</b>
Үйлдвэрлэлийн металлын хэмжээ, химийн цэврээр		кг	5.922	5.994	20.026	26.835	19.020	26.860	28.800	17.135	14.032	15.020	16.720	13.334	<b>209.698</b>
Баяжмалаас гарах алтны хэмжээ, химийн цэврээр			5.719	5.789	19.341	25.917	18.370	25.941	27.815	16.549	13.552	14.506	16.148	12.878	<b>202.527</b>
Дундаж агуулга		г/м <sup>3</sup>	1.906	1.930	1.934	1.728	1.225	1.297	1.113	0.720	0.678	0.725	0.807	0.953	<b>1.080</b>
Нөхөн сэргээлт	Дотоод овоолгоор дүүргэлт хийх	га				3.2	3.4	3.5	3.5	3.5	2.7	2.8	2.4		<b>25.0</b>
		мян.м <sup>3</sup>	182	125	790.74	848.6	800	949.89	953.64	982.88	842.86	710.99	711.84		<b>7898.4</b>
	Дотоод овоолгын тэгшлэлт, хэлбэржүүдэлт	га						3	2	2	2	1			<b>10.0</b>
		мян.м <sup>3</sup>						110	100	125	105	80			<b>520.0</b>
	Гадаад овоолгын тэгшлэлт, хэлбэржүүдэлт	га													<b>0.0</b>
		мян.м <sup>3</sup>													<b>0.0</b>
	Шимт хөрсөөр хучих	га					1	3	2		2	2			<b>10.0</b>
мян.м <sup>3</sup>						3	9	6		6	6			<b>30.0</b>	
Биологи		га							6			4		<b>10.0</b>	

#### 1.4. Төслийн байршил

“Галтын ам” нэртэй MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Төв аймгийн Заамар сумын нутагт Улаанбаатар хотоос баруун хойш 195 км, Заамар сумын төвөөс баруун тийш 35 км зайд оршино.



**Зураг 1-1. Төслийн талбайн байршлын зураг**

**Ордын байршил:**

Тусгай зөвшөөрөл нь байр зүйн хувьд М-48-137 хавтгайд нийт 3506,94 га талбайг хамрах ба газар зүйн солбилцлыг хүснэгт № 1-д үзүүлэв.

**Хүснэгт 1-3. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлын цэгүүд**

№	Булангийн цэг	Уртраг	Өргөрөг
1.	5336546.924 454148.257	104° 22'59.42"E	48° 10' 28.59"N
2.	5335886.802 454726.797	104° 23'27.69"E	48° 10' 38.49"N
3.	5336171.411 457469.644	104° 25'40.4"E	48° 10'49.82"N
4.	5331442.988 457308.808	104° 25' 34.32"E	48° 8'5.31"N
5.	5331434.604 448909.547	104° 18'47.94"E	48° 8'2.81"N
6.	5331790.894 448912.727	104° 18'47.94"E	48° 8'14.35"N
7.	5331791.924 448797.412	104° 18'42.36"E	48° 8'17.79"N
8.	5331898.132 448798.362	104° 18'42.36"E	48° 8'14.35"N
9.	5331899.864 448605.141	104° 18' 33.01"E	48° 8'17.79"N
10.	5331976.123 448605.825	104° 18' 33.01"E	48° 8' 20.26"N
11.	5331977.584 448443.398	104° 18'25.15"E	48° 8'20.26"N
12.	5332859.356 448451.342	104° 18'25.15"E	48° 8'48.82"N
13.	5332860.561 448317.866	104° 18'18.69"E	48° 8'48.82"N
14.	5333302.991 448321.862	104° 18'18.69"E	48° 9'3.15"N
15.	5333303.854 448226.412	104° 18' 14.07"E	48° 9'20.5"N
16.	5333839.525 448231.26	104° 18' 14.07"E	48° 9'3.15"N
17.	5333838.434 448351.905	104° 18'19.91"E	48° 9'20.5"N
18.	5333877.336 448352.256	104° 18'19.91"E	48° 9'21.76"N
19.	5333876.77 448415.057	104° 18'22.95"	48° 9'21.76"N
20.	5333934.505 448415.578	104° 18'22.95"E	48° 9'23.63"N
21.	5333934.062 448464.744	104° 18'22.95"E	48° 9'23.63"N
22.	5334003.529 448465.37	104° 18'25.33"E	48° 9'25.88"N
23.	5334003.081 448515.155	104° 18' 25.33"E	48° 9'25.88"N
24.	5334742.215 448521.809	104° 18'27.74"E	48° 9'49.82"N
25.	5334740.884 448669.906	104° 18' 27.74"E	48° 9'49.82"N
26.	5333876.399 448662.147	104° 18' 34.91"E	48° 9'21.82"N
27.	5333859.247 450610.012	104° 18'34.91"E	48° 9'49.82"N
28.	5334723.733 450617.478	104° 20'0.92"E	48° 9'21.82"N
29.	5334707.687 452511.76	104° 20'0.92"E	48° 9'49.82"N
30.	5336560.161 452527.147	104° 21'40.91"E	48° 10' 49.82"N

**1-5. Уурхайн ашиглалтын систем**

Уг орд нь ашиглалтын гүн ойролцоо, уул-геологийн нөхцөл харьцангуй энгийн тул тээвэртэй ашиглалтын системээр ил аргаар ашигладаг. Иймд бульдозероор эхэлж шимт хөрсийг ил уурхайн хил хүрээний гадна талд түрж шимт хөрсний овоолго үүсгэсний дараа түүний доорх хөрс болон элсэн давхаргыг экскаватор-автосамосвалын хослолоор зөөж тээвэрлэнэ.

Үндсэн хөрсийг урьд жилд ашиглалтын үйл ажиллагаа явагдан үүссэн хоосон орон зай руу шууд дотоод овоолго хийнэ. Алт агуулсан элсийг угаах төхөөрөмж байрласан талбайд зөөвөрлөнө. Хөрсний дотоод овоолго байгуулах замаар нөхөн сэргээлтийн ажлыг давхар хийж явна. Энэ нь хөрс болон шимт хөрсний давхаргуудыг холихгүйгээр анх байсан төлөвт нь эргүүлэн оруулж нөхөн сэргээлт хийх боломжийг бүрдүүлнэ.

Усан хангамжийн эх үүсвэр, усны хэрэглээ

***MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ***

Уурхайн ашиглалтын үед цэвэр усны үндсэн хэрэглэгчид нь элс угаан баяжуулах хэсэг, ажилчдын хотхон байна

Карьер болон орон байрны ундны усыг гүний ус болон гадаргын урсгал уснаас хангахаас гадна ариун цэврийн хяналтын шаардлагыг хангасан байна.

Угаах төхөөрөмжийн усан хангамжийг усан сан болон тунаагуураас хангах бөгөөд ууршилтын үр дүнд алдагдсан усны нөхөлтийг гадаргын усны урсац усаар хангана.

Уурхайд 120 хүн 318 хоног ажиллана гэж тооцвол 5724м3 ус ашиглана.

Төлөвлөлтөөр 187531 м3 элс угаан баяжуулах бөгөөд нөхөн сэлбэлтээр 150024,8м3 ус авч ашиглана.

Зам усалгааны хувьд 10 км урттай 6 м3 өргөнтэй замыг 2 лл нормоор 90 хоног усална гэж тооцоход 10800м3 ус ашиглана.

**Хүснэгт 1-4 Тэрбум мод төслийн хүрээнд таригдсан модны усалгаанд 6955м3 ус ашиглана.**

Услах сарууд	Услах модны тоо	1 удаагийн усалгаанд шаардагдах усны хэмжээ (л/мод)	Услах өдрийн тоо	Хэрэглэгдэх усны хэмжээ, м3
4-р сард	7560	30	3	680
5.01-6.15		40	7	2,117
6.16-8.15		30	12	2,722
8.16-9.15		30	5	1,134
Цэнэг усалгаа		40	1	302.40
<b>НИЙТ</b>				

**Хүснэгт 1-5 2026 оны усны хэрэглээ**

Хэрэглэгч	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Уурхайн хэрэглээ / Зам усалгаа /	метр.куб	10800
Баяжуулах үйлдвэрийн хэрэглээ / нөхөн сэлбэлтээр авах /	метр.куб	150025
Унд, ахуйн хэрэглээ	метр.куб	5724
Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээлтэд хэрэглэх хэрэглээ	метр.куб	6955
<b>НИЙТ ХЭРЭГЛЭЭ</b>	метр.куб	<b>773603</b>

2026 онд 173504 м3 цэвэр ус ашиглана.


**Хүснэгт 1-6 Цахилгааны хэрэглээ**

Хэрэглэгчдийн жагсаалт	Хэмжих нэгж	Тоон утга
Тосгоны хэрэгцээт чадал	кВт.цаг	120
Баяжуулах үйлдвэрийн хэрэгцээт чадал	кВт.цаг	465,35
Нийт хэрэглээ (тоолуурын заалт)	кВт/жил	3065757
Төлбөрийн хэмжээ	сая.төгрөг	1144,14

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

### 2.1 Төсөл хэрэгжих орчны байршил, физик газарзүйн нөхцөл

Заамар сумын нутаг дэвсгэр нь ерөнхийдөө талархаг болон сул толгод бүхий гадаргатай. Туул голын хөндий орчимд өргөн татмын тэгш тал давамгайлж, голоос алсрах тусам намсан толгод, дов толгод бүхий хэлбэрт шилжинэ. Далайн түвшнээс дээш дундаж өндөр нь 900–1,200 м орчим байна.



Зураг 2-1. Байгалийн бүс бүслүүр

### Бүс нутгийн геологийн ерөнхий тогтоц

Галтын ам нь Төв аймаг-ийн баруун хойд хэсэгт, Туул голын сав газарт байрлана. Тус бүс нь Хангайн бүсийн тектоникийн мужид хамаарах бөгөөд геологийн хувьд палеозойн настай тунамал, магмын болон хувирмал чулуулгууд өргөн тархсан. Суурь чулуулаг нь Палеозойн (девон–карбон) настай занар, элсэн чулуу, аргиллит, шохойн чулуу магмын чулуулгууд нь гранит, гранодиоритын биетүүд, хувирмал чулуулаг нь кварцит, сланец зэрэг байна.

**Дөрөвдөгчийн хурдас** - Галтын ам орчим нь алтны шороон орд бүхий бүс тул дөрөвдөгчийн аллювийн хурдас зонхилно. Голын хөндийн аллювийн элс, хайрга, бул чулуу, пролювийн болон делювийн гаралтай хурдас, хурдасны зузаан нь дунджаар 3–15 м (зарим хэсэгт түүнээс их) байх бөгөөд эдгээр хурдас нь алт агуулсан давхаргуудыг бүрдүүлдэг.

**Геологийн тогтоц** - Төслийн талбай орчмын геологийн тогтоц нь дөрөвдөгч галавын аллювийн болон делювийн хурдсаар голчлон бүрдсэн. Эдгээр хурдас нь элс, хайрга, шавранцар, лаг зэрэг материалаас тогтох ба алтны шороон хуримтлал үүсэх таатай нөхцлийг бүрдүүлсэн байдаг. Хангайн бүсийн тектоникийн мужид хамаарах бөгөөд геологийн хувьд палеозойн настай тунамал, магмын болон хувирмал чулуулгууд өргөн тархсан.

**Тектоник бүтэц** - Хагарал, ан цавын тогтолцоо сайн хөгжсөн, баруун хойш чиглэлтэй тектоникийн шугаман бүтэц давамгайлах ба алтжилт нь ихэвчлэн тектоник зааг, хагарлын бүсүүдтэй холбоотой.

**Газарзүйн тогтоц** - Дундаж өндөршил нь ойролцоогоор 1100–1300 м, хөндий, ам хэлбэрийн тогтоц давамгайлсан, голын татам, дэнж, нам дор хэсэг ихтэй, шороон ордын тархалттай (аллювийн хурдсаар баялаг)


**Уур амьсгал** - Эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө  $-30^{\circ}\text{C}$  хүртэл хүйтэрнэ, зундаа  $+25^{\circ}\text{C}$  орчим хална, жилийн хур тунадас дунджаар 250–300 мм, салхи ихтэй, хуурайшилт өндөртэй.

**Салхи** - Дундаж хурд: 3–5 м/сек, хавар салхи, шороон шуурга их, ил задгай талбайд элэгдэл үүсгэх нөлөөтэй.

## 2.2 Уулзүй

Галтын ам нь Хангайн нурууны өмнөд зах, Туул голын сав газрын бүсэд оршдог. Иймээс уулзүйн хувьд нам уул, толгодлог рельеф зонхилсон, голын хөндийтэй хосолсон онцлогтой.

**Байршлын уул зүйн мужлал** - Хангайн уулархаг муж, Орхон–Туулын сав газрын дэд муж, далайн түвшнээс дээш дундаж өндөр: 900–1,400 м, харьцангуй нам уулс, ухаа толгод ихтэй, нам уул, толгод, дугуйдуу оройтой 50–300 м харьцангуй өндөршилтэй, энгэрийн налуу  $5-20^{\circ}$ , голын хөндий нь аллювийн гаралтай, хайрга, элс давамгай, татам нь өргөн, зарим хэсэг намгархаг байдаг. Жалга сайрд нь түр зуурын урсацтай, усны элэгдлийн хэлбэрүүд тод илэрнэ.



Зураг 2-2. Өндөржилтийн зураг

## 2.3 Ус зүй

Заамар сумын гол усны эх үүсвэр нь Туул гол юм. Туул голын сав газар нь тухайн бүсийн газрын доорх болон гадаргын усны гол тэжээгч болдог. Мөн улирлын чанартай


горхи, булаг шанд цөөнгүй тохиолдоно. Хэрэглээний усны гадаргын эх үүсвэр нь Туул гол, түр зуурын горхи, булаг шанд байх бөгөөд газрын доорх ус нь аллювийн хурдсанд тархсан.

**Хур тунадас ба бороо** - Жилийн хур тунадас дунджаар 200–300 мм байх ба үүний ихэнх нь зун бороо хэлбэрээр орж гол, булаг шандын урсгалыг нэмэгдүүлдэг. Хавар цас хайлснаар богино хугацаанд голын төвшинг нэмэгдүүлдэг.

### **Усны урсгалын ерөнхий хэлбэр (графикийн тайлбар)**

Туул гол болон түүний салбаруудад усны урсгал нь улирлын шинж чанартай эрс хэлбэлзэлтэй байдаг. Ерөнхий гидрографийн хандлага нь зуны оргил үе болох 6-8 сард үргэлжилсэн урсгал их болдог.

Зуны бороо, цас хайлалт зэрэг нь усны урсгалыг оргилд нь хүргэдэг. Хур тунадас ихтэй үед голын урсгал хамгийн их байдаг. Энэ үеийг голын “ урсгалын оргил үе ” гэж тодорхойлдог. Өвлийн 12-2 сард голын урсгалын хамгийн бага үе байдаг ба энэ үед гол зөвхөн гүний усны тэжээлээр урсдаг. Үүнийг “ урсгалын нам дор үе ” гэж нэрлэнэ. Туул гол нь Монгол орны ихэнх урсгалтай адил хур борооны болон цас хайлалтын уснаас ихээхэн шалтгаална.



**Зураг 2-3. Ус зүйн зураг**

## **2.4 Хөрс**

Төслийн талбай орчмын хөрс нь ихэвчлэн хөнгөн механик бүрэлдэхүүнтэй, элсэнцэр болон шавранцар бүтэцтэй. Голын татмын бүсэд хар хүрэн болон аллювийн хөрс зонхилох ба уул уурхайн нөлөөлөлд орсон хэсгүүдэд хөрсний эвдрэл, шимт хөрсний нимгэрэл тодорхой хэмжээнд ажиглагддаг. Бүс нутагт бор хүрэн хөрс давамгайлах бөгөөд органик бодисын агууламж бага, эвдрэлд өртөмтгий байдаг. Голын хөндийд хайрга, элсэрхэг хөрс, хээрийн бүсийн хүрэн, хар хүрэн хөрс зонхилдог.


**Галтын амны хөрсний геологийн бүтэц.** Геологийн бүтэц нь ихэвчлэн дараах гол бүрэлдэхүүнтэй чулуулгуудаас тогтдог. Эдгээр чулуулгуудын элс, хайрга, шаварлаг хэсгүүд хөрс болон орчны усны урсгалд нөлөөгөөр өөрчлөгдөж янз бүрийн хөрсний



**Хүснэгт 2-1. Болзошгүй тохиолдох ховор ургамлууд**

Монгол нэр	Латин нэр	Статус (жишиг)	Тайлбар
Алтан гагнуур	<i>Rhodiola rosea</i>	Эмзэг (VU)	Уулын чулуурхаг хэсэг
Сибирь сонгино	<i>Allium altaicum</i>	Ховор	Уулын бүс
Хонин арц	<i>Juniperus sabina</i>	Эмзэг бүсэд	Уулын энгэр
Долоогоно (зарим зүйл)	<i>Crataegus spp.</i>	Бүс нутгийн хамгаалалттай	Голын сав

Галтын ам нь ихэвчлэн хээр давамгайлсан бүс тул өндөр уулын ховор зүйлийн ургамлын нягтрал бага. Гэхдээ голын сав, хад чулуурхаг хэсэгт ховор зүйл тохиолдох боломжтой.



**Таних тэмдэг**

1. Хялгана-зүр өвс-алаг өвст (20%) ба бутууль-алаг өвстэй (10%) шинэсэн болон шинэ-хусан ойн алаг өвс-үетэнт бүлгэмдэл

2. Тавилгана, харгана оролцсон хялгана-алаг өвст ба хялгана-улалж-алаг өвст

3. Биелэг-алаг өвс ба биелэг-улалж-алаг өвст

4. Баян бүрдийн чулуурхаг өвслөг-ботууль-бут өвстэй (20%) (чаргай, тавилгана, харгана) ба шинэ-хусан ойн өвслөг (10%) хялгана-алаг өвст бүлгэм

5. Улалж-улаантолгойт хотгорын жижиг дэгнүүлт үетэнт-алаг өвст бүлгэмдэл

6. Улалж-алаг өвстэй хайлаас, бургасан шугуй оролцсон үетэнт ба үетэн алаг өвст

7. Харгана оролцсон хялгана-ботууль-алаг өвст

8. Харгана оролцсон хялгана-жижиг дэгнүүлт үетэн-хиагт

9. Хиаг-улалжит (20%) ба дэрс-хиаг-бударгатай (10%) хялгана-хиаг-алаг өвст бүлгэмдэл

10. Бүйлээ, үхэр харгана (20%) оролцсон чулуурхаг хялгана-ботууль-алаг өвстэй хялгана-хяаар өвс-алаг өвст бүлгэмдэл

11. Зурман сүүлт (30%) ба нэг наст бударганат (20%) хиаг-улалжтай дэрс

12. Үетэн-алаг өвстэй (20%) ба бургасан төгөл (10%) бүхий загстай нишингэ-улалжит

**Зураг 2-5. Төслийн талбай орчмын ургамлан бүлгэмдлийн зураг**

## 2.6 Амьтны аймаг

Галтын ам нь ойт хээр-хээрийн шилжилтийн бүс, мөн Туул голын сав газар-т оршдог тул хээрийн болон голын хөндийн амьтад хослон тархана. **Хөхтөн амьтад**, Хээрийн бүсэд Чоно (*Canis lupus*), Үнэг (*Vulpes vulpes*), Хярс, Тарвага (*Marmota sibirica*), Зээр (зарим үед нүүдэллэн орж ирнэ), Дорго, Мануул (*Otocolobus manul*) – эмзэг ангилалд, Голын сав, бут

сөөгтэй хэсэгт, Усны оготно, Зараа, Булга ховор үзэгдэнэ. **Шувууд Хээрийн шувууд**, Бүргэд (*Aquila chrysaetos*), Хээрийн бүргэд, Харцага, Бозлог, Хээрийн галуу, **Усны шувууд** (голын орчим), Нугас, Хун (нүүдлийн үед), Цахлай, Зарим махчин шувууд бүртгэгдсэн байдаг. Хэвлээр явагч, Гүрвэл, Могой (хортой болон хортой биш зүйлс), Шавж, Цох, царцаа, Эрвээхэй, Зөгий, Шоргоолж, Шавж нь экосистемийн чухал хэсэг юм.

**Хүснэгт 2-2. Улаан номонд орсон боломжит зүйлс**

<b>Монгол нэр</b>	<b>Статус</b>
Мануул	Эмзэг (VU)
Тарвага	Ховор
Цоохор ирвэс (өндөр ууланд)	Нэн ховор
Зарим махчин шувууд	Хамгаалалттай

### 2.7 Нийгэм, эдийн засаг

Заамар сум нь Төв аймгийн баруун хойд хэсэгт оршдог бөгөөд хүн амын тоо жилээс жилд уул уурхайн үйл ажиллагаатай уялдан хэлбэлздэг. Байнгын болон түр оршин суугчид холимог бүтэцтэй. Хөдөлмөрийн насны хүн ам зонхилно, уул уурхайд ажиллагсдын хувь өндөр. Мал аж ахуй нь орон нутгийн иргэдийн уламжлалт аж ахуйн хэлбэр бөгөөд бэлчээрийн маллагаанд тулгуурлан хөгжиж байна. Үндэсний статистикийн мэдээллийн сангийн мэдээгээр Заамар суманд бүртгэлтэй малын тоо толгой нь дараах бүтэцтэй байна. Үүнд: адуу 20,280 толгой, үхэр 19,065 толгой, хонь 89,967 толгой, ямаа 144,269 толгой, тэмээ 211 толгой байгаа бөгөөд нийт малын тоо 273,792 толгой байна.

Малын бүтцийн хувьд ямаа болон хонь зонхилж байгаа нь тус сумын бэлчээрийн нөхцөл, малчдын аж ахуйн онцлогтой холбоотой юм. Мал аж ахуй нь сумын хүн амын амьжиргааны эх үүсвэр болохын зэрэгцээ мах, сүү, ноос, ноолуур зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх чухал салбар болж байна.

Нийгмийн дэд бүтэц: Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Цагдаагийн хэсэг, Банк, худалдаа үйлчилгээний байгууллагууд, Уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд сургууль, эмнэлэг, зам засвар зэрэгт хөрөнгө оруулалт хийдэг. Худалдаа, үйлчилгээ уурхай дагасан үйлчилгээ (шатахуун, засвар, хүнс), Барилгын болон тээврийн үйлчилгээ, жижиг бизнес эрхлэгчид байдаг.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

АЙ БИ БИ АЙ ХХК нь үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох эрсдэл буюу болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг зохион байгуулахад шатлалтайгаар бууруулах зарчмыг баримтална. Энэ нь биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга замаар хийгдэнэ. БОЯБ-ын стратегид дээрх сөрөг нөлөөллийг бууруулах шатлалыг дараах байдлаар тус тус тодорхойлсон байдаг.

1) Зайлсхийх – “Зайлсхийх арга хэмжээнүүд нь биологийн олон янз байдалд бодит нөлөөлөл үүсэхээс өмнө буюу олборлолтын болон баяжуулалт зэрэг уурхайн үйл ажиллагааг эхлүүлэхээс урьтан менежментийн өөрчлөлт хийх эсвэл тухайн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээнүүд юм. Үүнд өмнөх төлөвлөгөө үйл ажиллагаа, арга хэмжээг өөрчлөх шийдвэрүүд багтана”.

2) Багасгах – “Багасгах арга хэмжээнүүд нь аль хэдийн эхэлсэн олборлолтын болон боловсруулах үйл ажиллагааны үр дүнд биологийн олон янз байдалд учирч болох хохирлыг багасгаж болох арга хэмжээнүүд юм”.

3) Нөхөн сэргээх – “Нөхөн сэргээх арга хэмжээнүүд нь төслийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газар нутгуудад аюулгүй, тогтвортой газрын төрх, тог тцыг бий болгох бэлтгэл ажлууд, ургамалжуулж амьдрах орчныг дахин сэргээх ажил. Амьдрах орчныг сэргээх арга хэмжээ нь нөхөн сэргээлтээс бага зэрэг ялгаатай тал бий, энэ нь тухайн амьдрах орчныг эвдрэлд өртөхөөс өмнөх бүхий л нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ”.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг Галтын амны шороон ордын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлохдоо БОНХС-ын 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалын хавсралтад заасан аргачлалыг үндэслэжээ. Уг үнэлгээгээр:

**Хүснэгт 3-1 Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа**

Нөлөөлөлд өртөгч		Байгаль орчны сөрөг	
			Бага ба
Газрын гадарга	Барилга байгууламж, агуулах сав,		Дунд
	Дэд бүтэц		Дунд
Уур амьсгал	Нүүрстөрөгчийн хийн ялгарал		Дунд
	Цаг агаарын нөхцөл төслийн үйл		Бага
Агаарын чанарт үзүүлэх нөлөө			Дунд
Газрын хэвлийд үзүүлэх нөлөө			Их
Гадаргын усанд үзүүлэх нөлөө			Бага
Газрын доорх усанд үзүүлэх нөлөө			Дунд
Хөрсөнд үзүүлэх нөлөө			Их
Ургамалд үзүүлэх нөлөө			Их
Амьтны аймагт үзүүлэх нөлөө			Дунд

Гэсэн үр дүн гарсан.

### **3-1. Экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдал**

Төслийн үйл ажиллагаанаас экосистемийн өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, орчны чанарын өөрчлөлт, байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор, эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг энэ хэсэгт хамруулсан.

#### **Экосистемийн өөрчлөлт:**

Олборлолтын ажлын технологи нь ил уурхайн аргаар ухаж ачих-тээвэрлэх гэсэн процессуудаас бүрдэнэ. Иймд геологийн тогтцыг эвдэж өөрчлөх, газрын хэвлийн нөөц баялгийг ашиглах явцад бий болох ихэнх нөлөөлөл нь шууд нөлөөлөлд хамаарна. Ашиглалтын хүчин чадал бага боловч тухайн орон нутгийн байгаль-экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох хөрс, ургамлын нөмрөг, гадаргын усны нөөцөд шууд сөргөөр нөлөөлж буй эдгээр нөлөөлөл нь дунд хугацааны дунд хүчтэй нөлөөлөлд хамрагдах бөгөөд ихэнхдээ буцалтгүй шинжтэй байна. Түүнчлэн тоос шороо дэгдэн бичил уур амьсгалын нөхцөл богино хугацаагаар бага зэрэг өөрчлөгдөж болох юм.

Байгалийн баялаг, нөөц ашиглалт: Уурхайн үндсэн зорилго нь байгалийн баялгийг ашиглахад чиглэсэн бөгөөд нөлөөлөл нь мөн шууд, буцалтгүй шинжтэй юм. Иймд Монгол улсын Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах үүрэг хүлээх бөгөөд түүнийг сорчлон ашиглахыг хориглоно. Байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг жил бүрийн уулын ажлын төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх шаардлагатай.

Байгаль орчны чанарын өөрчлөлт: Уурхайн хэрэглээ, шатах тослох материал, хог хаягдал зэрэгтэй холбоотойгоор гадаргын ус болон хөрс бохирдсон тохиолдолд газрын доорх усны чанарт өөрчлөлт орж болзошгүй бөгөөд энэ нөлөөлөл нь дунд хугацааны, бохирдсон гадаргын болон газрын доорх уснаас мал, амьтан, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үр дагавар нь дунд зэрэг учир эрчим нь дунд зэрэг байна.

Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор: Байгалийн тогтоц буюу газрын гадаргын хэлбэршилд сөрөг нөлөөлөл үзүүлэх бөгөөд Туул дэнж хэсэгт дунджаар 32,0м, Галтын ам хэсэгт дунджаар 90м гүн, 27,3га талбай шинээр уулын ажилд, 3,2 га талбай шимт хөрсний овоолго үүсгэхэд, 5,1 га талбай гадаад овоолго үүсгэхэд, 1,0 га талбай зам хийхэд өртөх бөгөөд энэ тухайн нутгийн байгалийн унаган дүр төрх, ландшафтыг хүчтэй өөрчлөлтөд оруулах боловч нөхөн сэргээлтийг бүрэн хийснээр сөрөг нөлөөллийг багасгах, бууруулах боломжтой. Тус ордын нутаг орчим тусгай хамгаалалтай газар нутаг байхгүй.

Нийгэм, эдийн засаг: Ашигт малтмалыг олборлох үйл ажиллагаа нь улс, орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулахаас гадна 250 хүнийг ажлын байраар хангах ба ажлын байр нэмэгдэх нь тэдний амьжиргаанд тус нэмэр болж буй сайн талтай юм. Эдгээр нь шууд бөгөөд богино хугацааны эерэг нөлөөлөлд хамаарна.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага хэмжээнд байлгах, нөхөн сэргээлтийг стандартын шаардлагад нийцүүлэн боломжит хамгийн их хэмжээгээр хийхэд онцгойлон анхаардаг.

Манай компани байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Байгаль орчны бохирдлоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах
- Уурхайн барилга байгууламж барих, олборлолт хийх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэж, энэхүү биелэлтийн тайланг бичих.

**Хамрах хүрээ:** Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2026 оны Галтын ам алтны ордын ашиглалтын үйл ажиллагааны бүх үе шатыг хамарна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нь “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А-618 журмын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-удыг тус тус баримталснаас гадна байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурласан болно.

***MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ***

4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

4.1.1 Агаар орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

**Хүснэгт 4-1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаарын чанар	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх (дулааны улиралд усалгааг тогтмол хийх)	Уурхайн технологийн зам, туслах зам, баяжуулах руу хүргэх зам;	тн/км	0,03	90 орчим	Үйл ажиллагааны зардал	Тогтмол	Монгол улсын Агаарын тухай хууль MNS4585:2016 Агаарын чанарын стандарт-Техникийн ерөнхий шаардлага
		км		0,7	10 удаа	7,0	Тогтмол		
		Замаас үүсэх тоосжилтыг бууруулах - хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ. (шаардлагатай бол хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглээ байрлуулах)	Уурхайн технологийн зам, туслах зам;	км	0,1	Тодорхой лох боломжгүй	Үйл ажиллагааны зардал	Тогтмол	

**MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

		Ажилчдыг эрүүл ажиллах, амрах орчинг бүрдүүлэх зорилгоор уурхайн тосгоны ногоон байгууламжийг нэмэгдүүлэн,	Уурхайн тосгон;	м <sup>2</sup>	0,5	1	0,5	Нэг удаа	MNS 6260:2020 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах;
2	Гадаргын болон газар доорхи ус	Уурхайн ундны усны хэрэглээг тогтмол бүртгэх, ашиглах усны хэмжээг зорилгод түвшинд байлгах;	Уурхайн тосгон;	м <sup>3</sup>		Баталгаажуулсан усны тоолуурын заалтаар	Усны төлбөрт орсон	Тогтмол	MNS0900:2018 Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” - MNS4943:2015. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар, хаягдал ус. Ерөнхий шаардлага”
		Уурхайн ногоон байгууламж усалгаанд зориулж ус ашиглах;	Уурхайн хэсэг;	га	10		Усны төлбөрт орсон.	2, 3-р улирал	
		Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах	Уурхайн нийт ажилчид	Сургалтанд хамрагдсан ажилчдын тоогоор, мэдээллийн хуудас, тараах материалын тоо	Дотоод зардал	4	Үйл ажиллагааны зардал	Жил тутам, бүх ажилчид сургалтад хамрагдах	
		Усыг үр ашигтай хэрэглэх талаар ухуулга, сурталчилгааг ажилчдад хийх, мэдээллийн хуудсыг зарын самбарт байрлуулж шинэчилж байх			Дотоод зардал	Тодорхой лох боломжгүй	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны туршид	

*MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ*

3	Хөрсөн бүрхэвч	Аливаа газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт болон шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож, тогтоосон хэмжээнд хуулж, бүртгэл хөглөх, хаягжуулах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	га/м3	Дотоод зардал	Газар хөндөх зөвшөөрлийн хүсэлт бүрт	Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт;
		Газарзүйн мэдээллийн системд шимт, шимэрхэг хөрсний овоолгийн байршил, хэмжээг бүртгэх, зурагжуулах, тухайн овоолгыг газар дээр нь хаягжуулах		Дотоод зардал	Үйл ажиллагааны зардал				
		ШТМ хөрсөнд алдагдахаас сэргийлэх;		л/м2	0,75		2		
4	Газрын гадарга	Зайнаас тандан судлах аргазүйг ашиглан газар ашиглалтыг хянах,	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	га/м3	Дотоод зардал		Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	"АЙ БИ БИ АЙ" ХХК -ийн "Газар хөндөх журам"

**MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

		Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл (ГХЗ) авах,		га/м2	Дотоод зардал		Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	
5	Ургамлан нөмрөг	Байгаль орчны доройтол, цөлжилтийг бууруулах зорилгоор Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх;		5000	0,005	1 удаа	25,0	2 болон 4-р улирал	MNS 6140:2010 Техникийн шаардлага, MNS 6254:2011 Мод, сөөгний суулгацыг бойжуулах. Ерөнхий шаардлага
6	Амьтны аймаг	Ховор болон нэн ховор амьтад, тэдгээрийн нүүдэл, шилжилт хөдөлгөөн, мөн төслийн талбайн дотор болон гадна анхаарал болгоомжтой зорчих талаар нийт	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	хамрагдсан ажилчдын тоо	Дотоод зардал		Үйл ажиллагааны зардал	Нэг удаа	Байгаль орчныг хамгаалах тухай хууль

**MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

		ажилчид, туслан гүйцэтгэгч нарт сургалт явуулах							
		Ган зуд болон байгалийн цаг уурын хүнд нөхцөл үүссэн тохиолдолд зэрлэг амьтдыг хамгаалах Биотехникийн арга хэмжээг зохион байгуулах	Ховор зүйлийн амьтдын зам дагуу	1 удаа	0,8	1	0,8	Жилд 2 удаа зохион байгуулах боломжтой	Заамар сумын байгаль орчны байцаагч болон байгаль хамгаалагч нарын зөвлөмжийг үндэслэн зохион байгуулна
7	<b>Нийт сая.төг</b>	<b>34,8 сая төгрөг</b>							

**4.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө**

Уурхайн ахилт, бүтээн байгуулалт, зам талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэж, стандартын дагуу хамгаалж эвдрэлд өртсөн газарттехникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

**Хүснэгт 4-2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө**

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8

**MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.	Техникийн нөхөн сэргээлт	Дотоод овоолгоор өмнө нь олборлосон талбай руу отвальдах замаар нөхөн дүүргэлт хийж шимт хөрсөөр хучина.	га	10	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны зардал	Байнга	Нөхөн сэргээлтийн ажлын стандартууд
2.	Биологийн нөхөн сэргээлт	Олон наст ургамал тарих	га	10	5,6	56,0	Жилд 1 удаа	
<b>Нийт</b>						<b>56,0</b>		

4.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4-3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Нийт зардал, сая..төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
	Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	Техникийн нөхөн сэргээлт	Дүйцүүлэх	3.0	5,0	15,0	Жилд нэг удаа	Нөхөн сэргээлтийн стандарт

4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4-4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, сая.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
---	-----------------------	-------------------------------	----------------------------	------------	------------------------	----------------------	--------------------------------	---------------------------------

**MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	1	2	3	4	5	6	7	8
1.	Нутгийн малчин өрхүүд	Галтын амны дээд хэсгийн алтны шороон ордын талбайд 2025 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах талбайн ойр орчимд нөлөөлөлд өртөх объект, малчин өрх байхгүй болно.	Лицэнзийн хэмжээнд	-			Жилд 1 удаа	
	<b>Нийт</b>					<b>0</b>		

4.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

**Хүснэгт 4-5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Археологийн дурсгал	Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд археологийн дурсгал байхгүй бөгөөд орд гарзын ашиглалтын явцад илрэвэл тухай бүрд мэргэжлийн байгуулагад мэдэгдэнэ. Нийт ажилчдад сургалт зохион байгуулна.	Лицэнзийн талбайн хэмжээнд	2	0,05	0,1	Жилд 1 удаа	
2.	Палеонтологийн дурсгал	Тусгай зөвшөөрлийн	Лицэнзийн				Жилд 1 удаа	

**MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

		талбайн хэмжээнд палеонтологийн олдвор байхгүй бөгөөд орд гарзын ашиглалтын явцад илрэвэл тухай бүрд мэргэжлийн байгуулагад мэдэгдэнэ. Нийт ажилчдад сургалт зохион байгуулна.	талбайн хэмжээнд	2	0,05	0,1		
	<b>Нийт</b>					<b>0,2</b>		

4.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 4-6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал сая.төг	Нийт зардал сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
	1	2	3	4	5	6	7	8
1	Аюултай бодис асгарах	Химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материал, тосох сав зохих газруудад байрлуулах	Засвар үйлчилгээний хэсэг	*		1,5	Тогтмол	аюултай бодисын тухай хууль
		ШТМ алдагдсан үед шингээгч, саармагжуулагч материалыг зохих газруудад байршуулах		*		1,5	Тогтмол	
2	Гал түймэр	Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах боломжтой бүх арга хэмжээг авах	Үйл ажиллагаа явуулж буй бүх барилга байгууламж	3 удаа	3,0	9,0	Тогтмол	Галын аюулгүй байдлын тухай хууль,

**MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

		Галын сургалт, семинар орох	Нийт ажилчдад	Сургалтант суусан ажилчдын тоогоор	1,0	4,0	4 удаа	Гамшгаас хамгаалах тухай хууль
3	Химийн бодис	Химийн хорт бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагааг зохих шаардлагын дагуу явуулах	Ашиглалтаас гарсан аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагуудад нийлүүлэхэд бэлдэж савлах, тусгай талбайг цуглуулах	1	1,5	1,5	*	*
4	<b>Нийт сая.төг</b>	<b>17,5 сая төгрөг</b>						

4.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

**Хүснэгт 4-7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө**

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн хаягдал	Ахуйн хог хаягдлын цэгийг нэмэлтээр сайжруулах;	Уурхайн тосгон;	м2	1,5	1	1,5	1 удаа	Хог хаягдлын тухай хууль;
		Ангилан ялгах зориулалт бүхий хогийн савны тоог нэмж байршуулах;	Уурхайн тосгон;	ширхэг	1,0	1	1,0	1 удаа	

***MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ***

2	Үйлдвэрийн хаягдал	Хаягдал дугуй, машин техникийн хаягдал төмөр, сэлбэгийг нэг цэгт төвлөрүүлэх талбайг тохижуулах;	Засвар үйлчилгээний хэсэг;	м2	1,5	1	1,5	1 удаа	Хог хаягдлын тухай хууль;
3	Аюултай хог хаягдал	Засвар үйлчилгээний төвд ангилан ялгах түр хогийн цэгийг сайжруулах;		м2	1,0	3	3,0	1 удаа	Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт бодисын тухай хууль;
4	Ахуйн болон аяултай	Хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах			3,0	1	3,0	1 удаа	
5	<b>Нийт сая.төг</b>	<b>10,0 сая.төг</b>							

4.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

**Хүснэгт 4-8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**

**MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, сая.төг	Нийт зардал, сая.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Худгийн түвшин хэмжилт	Худгийн усыг хэмжих багаж	*	1		2,0		
		Малчны гар худагт	Сар бүр			Үйл ажиллагааны зардал	Дотоод үйл ажиллагаа	
2	Агаарын шинжилгээ Тоосонцорын шинжилгээ O <sub>2</sub> , SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , CO Бага хурдтай дээжлэгч	Уурхайн карьер, Шатахуун түгээх станц, Засвар үйлчилгээний төв, Уурхайн тосгон төв, Уурхайн тосгон	3 дугаар улирал	Жилд 3 удаа	0,1	0,3	Гэрээт лабораторид шинжлүүлнэ.	MNS 3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага, MNS 5061:2001. Нүүрс Хүчлийн хий-CO <sub>2</sub> тодорхойлох эзэлхүүний арга, MNS 0012-1-015:1987. Азотын давхар исэл
3	Усны шинжилгээ Бактериологийн бүрэн шинжилгээ, Усны ерөнхий химийн шинжилгээ	Унд ахуйн худаг, хоол үйлдвэрлэлийн хэсэг, нийтийн ариун цэврийн өрөө	2,3,4-р дүгээр улиралд	Жилд 3 удаа	0,25	0,75		MNS 0900:2018 Ундны усны эрүүл ахуйн шаардлага чанар, аюулгүй байдлын үнэлгээ

**MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

4	Хөрсний шинжилгээ Хүнд металлийн шинжилгээ	Уурхайн карьер, Шатахуун түгээх станц, Засвар үйлчилгээний төв, Уурхайн тосгон	3 дугаар улирал	Жилд 1 удаа	0,2	0,2		MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
<b>Нийт зардал</b>				<b>4,0 сая.төг</b>				

**4.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

**Хүснэгт 4-9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв /сая. төг/	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			Сар 5	Сар 8	Сар 11		
1	2	3	4	5	6	7	
1	Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх;	10,0	+	+	+	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	Аудитын зөвлөмжийн дагуу ажлын тайланг бичих;
2	Байгаль орчныг хамгаалах тэмдэглэлт өдрүүдийг төлөвлөгөөндөө тусган орон нутгийн байгууллага болон сумын байгаль орчны байцагч тай холбогдон зохион байгуулах;	2,0	+	+	+	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	Байгаль хамгаалах хавар, намрын сарын аян, Дэлхийн усны өдрүүдийг тэмдэглэх;

**MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

4	Байгаль орчныг хамгаалах талаархи сургалт семинарыг ажилтан, ажиллагсдад орох;	0,5	+	+	+	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	Жил бүр байгаль орчныг хамгаалах ажлын хүрээнд сургалт семинар орох;
5	<b>Нийт сая.төг</b>	<b>12,5 сая.төг</b>					

**4.10 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө**

**Хүснэгт 4-10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө**

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, сая. төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Заамар сумын байгаль орчны байцаагч болон байгаль хамгаалагчид шаардлагатай мэдээ тайланг хүргүүлэх	Танилцуулга	Мэдээ тайлангууд	Улиралд 1 удаа	Үйл ажиллагааны зардал	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	
2	Шалгалтын комисс	Танилцуулга	Биелэлтийн тайлан	11 сар	Үйл ажиллагааны зардал	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	Уурхай дээр
3	<b>Нийт</b>	<b>Үйл ажиллагааны зардалд оруулан тооцсон.</b>					

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал**

**Хүснэгт 5-11. 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардал**

<b>№</b>	<b>Арга хэмжээ</b>	<b>Зардал, сая.төг</b>
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ	34,8
2	Нөхөн сэргээлт	56,0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	15,0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	0,2
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	17,5
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	10,0
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	12,5
9	Орчны хяналт шинжилгээ	4,0
10	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах	0
	<b>Нийт зардал, мян.төг</b>	<b>150,0</b>

Тус уурхай нь БОННУ-д тусгаснаар 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийтдээ 150,0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж байна.